

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

Захиалагч: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Гүйцэтгэгч: Ажиглалт ХХК

УЛААНБААТАР ХОТ

2025 он

АГУУЛГА

Нэг.Ерөнхий мэдээлэл	3
Хоёр.Төрийн байгууллагад үүсэх зардал	6
Гурав. Хуулийн этгээдэд үүсэх зардал	7
3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох.....	8
3.2.Нэг бүрийн зардлыг тооцох.....	8
3.3.Тоон үзүүлэлтийг тооцох.....	10
3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах.....	11
3.6.Нэмэлт зардлыг тооцох.....	11
Дөрөв. Иргэнд үүсэх зардал	15
Тав.Улсын төсөвт төвлөрөх орлогын нөлөөлөл	16
Зургаа.Дүгнэлт	21

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг уг хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийсэн.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, түүнийг хялбарчлах, буруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго оршино.

Энэхүү тооцоололд дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- ✓ Төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэд энэхүү хуулиар хүлээсэн үүргийг оновчтой тодорхойлох;
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчаас хүлээн авч, зохицуулалтыг судлан үзэхэд хуулийн төсөл атлагдсанаар зардал тээгч хуулийн этгээд болон төрийн байгууллагад тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь “нэмэлт, өөрчлөлт” хэлбэрээр бичигдэж байгаа буюу тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан хуультай, түүний дагуу холбогдох иргэн, хуулийн этгээд, байгууллага хуулийг дагаж биелүүлж байгаа тул зөвхөн нэмэлт, өөрчлөлт орж байгаа хуулийн төслөөр шинээр бий болгохоор заасан болон өмнө гүйцэтгэж байсан үүргийг өргөжүүлсэнтэй холбоотой үүсэх зардлыг тооцоолсон болно.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул зарим үүрэгтэй холбоотой бодит статистик болон зарцуулах хугацааг тооцоолоход шууд ашиглах тоо баримт байхгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн бусад адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, түүнд

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

үндэслэн баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах, ярилцлага зохион байгуулах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Шинээр үүсч буй чиг үүргийн тухайд:

ХУУЛИЙН ЭТГЭЭД:

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр “Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх” зохицуулалтыг шинээр тусгасан байна.

28¹ дугаар зүйл: Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх

28^{1.1}.Баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

28^{1.2}.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд энэ хуулийн 281.1-д заасан баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй.

28^{1.3}.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүсэх үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана.

28² дугаар зүйл: Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

28^{2.2}.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

28^{2.2.1}.үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;

28^{2.2.2}.химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу устгах;

28^{2.2.3}.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөх;

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА:

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төрийн байгууллагад шинээр чиг үүрэг ачаалал, нэмэгдээгүй ба улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн геологийн судалгааны ажлыг хувийн хэвшлийн хөрөнгөөр, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, мөн тухайн судалгааны ажлын үр дүнг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг тусгасан.

УЛСЫН ТӨСӨВТ НЭМЭГДЭХ ОРЛОГО:

Хуулийн төслийн хүрээнд зарим төрлийн зөвшөөрөлтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамж, төлбөрийн орлого нэмэгдэхээр байна.

42¹ зүйл.Олон нийтийн оролцоо

421.2.Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно:

421.2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгд оролцох, санал, зөвлөмжөгөх;

421.2.6.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж

байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.”

ХОЁР.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргадаг.

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг аргачлалын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолсон. Үүнд:

- Үүргийг тогтоох;
- Хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах;
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох — тухайн хууль тогтоомжид хамаарах (1) төрийн байгууллага, (2) тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг үзэхэд шинээр чиг үүрэг нэмэгдээгүй байна.

Тиймээс ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох — хүний нөөцийг тодорхойлох шаардлагагүй ба төрд ямар нэгэн нэмэлт ачаалал, зардал үүсэхгүй байна.

Дүгнэлт

Ашигт малтмал баяжуулах тусгай зөвшөөрлийг хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгажээ.

Ашигт малтмалын тухай хуулийн тодорхой төрлийн тусгай зөвшөөрлийг олгодог ба уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагад шинээр үүсэх ачаалал, чиг үүрэг байхгүй ба хуучин олгож байсан тусгай зөвшөөрлийн төрөл дээр **“Баяжуулалтын тусгай зөвшөөрөл”** нэмэгдсэн байна.

Мөн “Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгааг нь зарлагдаж буй бүх талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэргээр хэтийн төлөв бүхий талбай бага буюу хөрөнгө оруулагчдын сонирхож буй талбай зарлагдахгүй байх тул гэрээгээр олгох болсон нь үйлчилгээг хөнгөвчилж, зардал хэмнэж байна.

ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Энэ хэсэгт Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үйлчлэлд хамаарахаар заасан хуулийн этгээдүүд тамхи импортлох, худалдаалах зөвшөөрлийг шинээр авахад буюу одоо зөвшөөрөлтэй эрхлэхээр заагаагүй боловч хуулийн төслийн өөрчлөлтийн улмаас зайлшгүй зөвшөөрөл авахаар болж байгаа хуулийн этгээд уг үүргийг хэрэгжүүлэхэд тэдэнд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- нэмэлт зардлыг тооцох.

Аргачлалын 2.3 дахь хэсэгт гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо, баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг заасан.

Тиймээс бүх төрлийн хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмждэг, зөвшөөрөл хүсэх гэх мэт бусад этгээдэд зайлшгүй гаргаж өгөх мэдээллэх үүргүүдийг хамааруулж ойлгоно.

Тухайлбал, тухайн хуулиар төрийн байгууллагад ямар мэдээ, мэдээлэл, тайланг хуулийн этгээдээс гаргах вэ, түүнд хэдий хэр цаг хугацаа зарцуулах, шинээр бий болгох үүрэгтэй ойролцоо өөр ямар үүрэг байна, түүнд хэдий хэр хугацаа зарцуулдаг вэ? гэх мэт судалгаа авсан.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг доорхи 6 алхам буюу үе шатаар тооцож гаргалаа. Нийт зардлыг хүснэгт 4 тодорхойлж харуулжээ.

3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдүүд нь дараах үүргийг хүлээж байна.


Хүснэгт 1: Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдүүдийн хүлээх үүрэг.

№	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга
1	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл 1-р бүлэг	28 ¹ .1.Баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ. 32.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь жил бүр 10,000,000 төгрөг байна.

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

3.2.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт хуулийн этгээдийн ажилтантай уулзалт ярилцлага хийх дүнд бий болсон үр дүнг ашигласан болно.

Гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов. Түүнчлэн, хуулийн этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хэмжих боломжтой ажлыг хамааруулдаг. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн хувьд хууль, тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан дараах 2 төрлийн мөнгөн зардлыг тооцно:

1. Үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа;
2. Ажилтан олгох цалингийн зардал.

Хүснэгт 2: Зарцуулах хугацаа

Үүрэг	Агуулга	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/
Баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй байх	Шинээр авах	Өргөдөл бичих	60
		технологийн болон үйлдвэрлэлийн туршилтыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийлгэсэн байх	1440
		байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан байх	1440
		газрын хэвлийн баялгийн нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөх	30

	үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх	480
	Бусад төрлийн баримт бүрдүүлэлт	2400
	үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх	480
Нийт хугацаа		6330

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

Хуулийн этгээдэд үүсч байгаа хоёр төрлийн үүргийг хэрэгжүүлэхийн үйлдэл бүрт зарцуулах хугацааг удирдлага болгон нийт зарцуулах хугацааг үүрэг тус бүрээр гаргав.

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар² "2024 оны 3 дугаар улирлын байдлаар уул уурхайн салбарын ажиллагсдын сарын цалин 5.196.300 төгрөг байгааг судалгаанд дурдсан байх тул уг тоог үндсэн суурь болгон ашиглалаа.

Ажиллах хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд³ заасан ажлын цагийг баримтлав.

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
5.196.300 : 22 өдөр : 8 цаг = 29.524,4 төгрөг /нэг цагийн ажлын дундаж хөлс/ 29.524,25 : 60 минут = 492 төгрөг /нэг минутын цалин/

Хүснэгт 3: Ажлын хөлсний зардал

№	Үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	Тусгай зөвшөөрөлтэй байх	6330	492 төгрөг	3.114.360

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

3.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁴ болон **давтамжийг**⁵ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр "тоон үзүүлэлт" нь илэрхийлэгдэх юм. Давтамжийн хувьд хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28^{1.5}-д баяжуулалтын тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, 3 жилийн хугацаагаар сунгаж болно. Тиймээс тусгай зөвшөөрлийг 10 жилээр олгох тул давтамж нь 0,01, сунгалт нь 0.3 байна.

ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

² http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

³ Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1999 оны №25 дугаарт хэвлэгдсэн.

⁴ "Тохиолдлын тоо" гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

⁵ "Давтамж" гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагауг үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

Хүснэгт 4: Тохиолдлын статистик⁶

Он	2021	2022	2023	2024	2025-9 сар	Нийт	Дундаж
Ашиглалт нийт	54	37	25	42	26	184	36
Хайгуул	Өргөдөл	0	0	0	0	0	0
	Сонгон	109	50	213	63	77	512
	ЗГ-ын 216 тогтоол			2			2
	ЗГ-ын тогтоол		7				7
Хайгуул нийт	109	57	215	63	77	521	104

Дээрх статистик мэдээллээс харахад жил дунджаар ашиглалтын 36, хайгуулын 104, нийт 140 тусгай зөвшөөрөл шинээр олгож байна.

Дээрх үзүүлэлтийг ашиглан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар шинээр үүссэн гурван төрлийн чиг үүргийн тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 5: Тоон үзүүлэлт

№	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	х	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Тусгай зөвшөөрөлтэй байх	140	х	0.01	=	1.4

3.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах

Зардлын нийт дүнг тооцож гаргадаг. Ингэж тооцоходоо тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргасан. Хуулийн төсөлд ажил, үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан хуулийн этгээдүүдийн зардлыг тооцоолоход **299.4 сая** төгрөгийн зардал гарах ба энэхүү зардал нь зөвхөн үүргийг гүйцэтгэхэл зарцуулах захиргааны зардал байна.

$$\text{НИЙТ ЗАРДАЛ} = \text{ЗАРДАЛ} \times \text{ТООН ҮЗҮҮЛЭЛТ}$$

Өөрөөр хэлбэл өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж, нийт зардлын дүн гарна.

Хүснэгт 6: Зардлын тооцоо

№	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал
1	Тусгай зөвшөөрөл авах	3.114.360	1.4	4.360.104 ₮

Эх сурвалж: "Ажиглалт" ХХК

Үүнээс үзэхэд тухайн үүргийг гүйцэтгэхэд аж ахуйн нэгжийн захиргааны зардал 4.360.104 төгрөг байна энэхүү зардал дээр тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг нэмэлт төлбөр зардал гарна.

3.5. Нэмэлт зардлыг тооцох

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр

хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтод хамруулж ойлгох бөгөөд дараах нэмэлт зардал гарна.

Баяжуулах, боловсруулах (боловсруулах) тусгай зөвшөөрөл авахад шаардагдах зардал нь олон хүчин зүйлээс хамаарна — талбай, хүдэрний төрөл, үйлдвэр байгуулах хэмжээ, техник, зураг төсөл, байгаль орчны үнэлгээ гэх мэт. Тийм ч учраас яг тогтсон “тоог” хэлэх боломжгүй ч хэрэгтэй гол зардлын ангиллууд, болон хамааралтай хэмжигдэхүүнүүдийг доор товч өгье:

Доорх зүйлсийг зөвшөөрөл авах явцад бий болох зардлууд гэж тооцдог:

№	Зардлын төрөл	Тайлбар / шаардлага
1	Өргөдөл, хураамж, татвар	Тусгай зөвшөөрөл хүсэхэд төрийн хураамж, лицензийн хураамж, бүртгэлийн зардал
2	Зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэл	Баяжуулах / боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах, эдийн засгийн тайлан
3	Байгаль орчны үнэлгээ (БОНБУ), нөлөөллийн үнэлгээ	Үйл ажиллагааны нөлөөллийг судлах, зөвшөөрөл авах
4	Хүний нөөц, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ	Инженерүүд, геологич, техникийн зөвлөх үйлчилгээний төлбөр
5	Хяналт, аудит шалгалт, зөвшөөрлийн зөвлөлтийн хураамж	Мэргэжлийн зөвлөлүүдийн дүгнэлт, тусгай зөвшөөрлийн комиссын хурал, аудитын тайлан
6	Тээвэр, логистик, материал	Хүнд тоног төхөөрөмж зөөвөрлөх, материал нийлүүлэх зардал
7	Бусад зардал	Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хууль зүйн зөвлөгөө, гэрээ, үйлчилгээний зардал

Монгол Улсын жишээ, хураамжийн хэмжээ:

Зардлын зарим жишээ хэмжээ, лицензийн хураамжийн зарим тоо баримтыг доор дурдаж болно:

- Ашигт малтмалын лицензийн жилийн хураамж,
- Шохойн чулуу, нүүрс зэрэг ашигт малтмалд хураамж,
- Баяжуулах тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгоно, “ жилээр сунгана,
- Төлбөрийн хуваарь, хугацаа, хүү, торгууль зэрэг нөхцлүүд тухайн хуулиар заасан байдаг.

Төсөөлөл: Жижиг хэмжээний баяжуулах үйлдвэр байгуулах зорилготой төсөлд зөвхөн зөвшөөрөл авах, зураг төсөл боловсруулах, байгаль орчны үнэлгээ гээд суурь зардал нь хэдэн арван саяас тэрбум хүртэл төгрөгт хүрч болно. Том хэмжээний үйлдвэр, стратегийн ордод энэ зардал илүү өндөр байх боломжтой.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

№	Барааны нэр	Хэмжих нэгж	2024	2025 - VIII	өөрчлөлт	
					+/-	%
1	Нүүрс	тн/ам.дол	114.1	68.3	-45.7	-40.1
2	Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,896.6	2,368.4	471.8	24.9
3	Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	82.3	71.5	-10.8	-13.1

4	Цайрын баяжмал	тн/ам.дол	1,416.2	1,543.6	127.3	9.0
5	Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	232.8	189.6	-43.3	-18.6
6	Молибдены баяжмал	тн/ам.дол	15,451.0	15,966.8	515.9	3.3
7	Алт	тн/ам.дол	73,407.8	101,080.8	27,673.0	37.7

Дүгнэлт

Энэхүү зардлын тооцооллоос харахад жилд дунджаар тусгай зөвшөөрөл жилд 140 хүсэлтийг шийдвэрлэж байна. Тухайн үйлчилгээ авахад 1 хуулийн этгээдээс **5.145.336** төгрөгийн захиргааны зардал гарах ба үүн дээр тусгай зөвшөөрлийн төрөл, талбайн хэмжээсээс хамрааран 1 гектар тутамд 14.500 – 104.00 төгрөгийн төлбөр болон ашигт малтмалын төрлөөс хамааран ашигтмал ашигласны төлбөр тооцогдоно.

Иймд тухайн хуулийн этгээдийн үүсэх үйл ажиллагаа зардал нь эзэмших талбайн хэмжээс болон болон олборлосон ашигт малтмалын төрөөл хамааран харилцан адилгүй байна.

Мөн хуулийн этгээдэд гарч байгаа нэмэлт зардал нь бүх төрлийн татвартай холбоотой зардал байх тул зардлыг Хуулийн төслийн 28² дугаар зүйлд хуулийн этгээд нь “баяжмал, бүтээгдэхүүнээ худалдах” эрхтэй ба түүнээс олох орлоготой харьцуулахад хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байна.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэр нь ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад бүрэн хамруулна. Ингэснээр, тусгай зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаарч ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна.

Ялангуяа, гарал үүсэлгүй хүдрийг хяналтгүйгээр худалдан авч хууль бус олборлолтыг өөхшүүлэх, татвараас зайлсхийхээс гадна баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил далд байдлаар хяналтгүй ашиглах, хаягдлын далан, аж ахуйн горим алдагдах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх, хаалтын болон явцын мониторинг хийгдэхгүй байх зэрэг олон сөрөг үр дагавар үүсгэж буй гажуудлыг арилгана.

“Ашигт малтмал баяжуулах” тусгай зөвшөөрлийн тухай зохицуулалтын хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгасан нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэхэд ямар нэгэн нэмэлт зардал гарахааргүй байна.

ДӨРӨВ.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох ажлыг доорхи 5 үе шатаар хийсэн. Үүнд:

- Үүргийг тогтоох;

- Хугацаа, зардал тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт дүнг тооцож гаргах;
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах.

Иргэний хувьд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхдээ холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацааг /ачаалал/ тооцно.

Хуулийн төслийн “42¹ зүйлд “Олон нийтийн оролцоо” буюу иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцохоор тусгасан байна. Үүнд:

- салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгд оролцох, санал, зөвлөмж өгөх;
- салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх;
- салбарын хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;
- холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;
- эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх;
- ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.

Дүгнэлт

Иргэнд үүсэх үүрэг нь заавал гүйцэтгэх үүрэг биш сайн дурын үндсэн дээр хийх үүрэг учраас зардал тооцох шаардлагагүй гэж үзэж байна.

ТАВ. УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРӨХ ОРЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ

Ашигт малтмалын үйл ажиллагаанаас улсын төсөвт төвлөрөх орлого нь хэд хэдэн эх үүсвэрээс бүрддэг. Монгол Улсад дараах үндсэн төрлөөр төсөвт орлого төвлөрдөг:

1.Татварын орлого:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ): Борлуулалтын орлогоос тодорхой хувь хэмжээгээр (алт, нүүрс, зэс, төмөр зэрэгт ялгаатай хувьтай) улсын төсөвт төлдөг.
- ААНОАТ (Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар): Уурхай, баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн ашигт ногдуулдаг.
- НӨАТ (Нэмэгдсэн өртгийн албан татвар): Дотоод борлуулалт, импортын хэмжээнээс.
- Гаалийн татвар: Ашигт малтмал, бүтээгдэхүүн экспортлох, зарим тохиолдолд импортын бараанд ногдуулна.

2.Төлбөр, хураамж:

- Тусгай зөвшөөрлийн төлбөр: Хайгуул, ашиглалтын лицензийн жилийн төлбөр.
- Газрын төлбөр, ус ашигласны төлбөр: Уурхайн үйл ажиллагаанд хэрэглэж буй газрын болон усны нөөцийн төлбөр.

3. Ноогдол ашиг:

- Улсын өмчит болон төрийн хувь оролцоотой уул уурхайн компаниуд (жишээ нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Оюу Толгой” ХХК-д төрийн эзэмшлийн хувь) ашигт ажиллагаанаасаа ноогдол ашиг улсын төсөвт өгдөг.

4. Тусгай сангууд руу төвлөрөх орлого:

Ирээдүйн өв сан (УИХ-аас тогтоосон хэмжээгээр уул уурхайн орлогын тодорхой хэсгийг хуримтлуулдаг)

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ХУВААРИЛЖ БАЙСАН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ДҮН /төгрөг/

№	Аймгийн нэр	2021	2022	2023	2024	2025 - VIII
1	Архангай	3,556.9	5,935.5	9,604.8	12,238.7	9,230.3
2	Баян-Өлгий	4,973.9	5,751.7	9,095.1	11,329.4	8,760.0
3	Баянхонгор	3,748.5	7,911.2	12,469.8	19,673.8	15,987.7
4	Булган	2,217.1	5,185.5	8,197.2	13,414.1	10,286.7
5	Говь-Алтай	6,316.9	8,241.3	13,027.0	15,714.4	16,762.5
6	Дорноговь	14,041.2	12,483.9	19,192.6	37,861.9	28,254.4
7	Дорнод	5,220.0	12,307.8	15,387.6	22,143.2	19,710.0
8	Дундговь	3,519.1	5,817.0	9,159.2	13,920.6	11,252.8
9	Завхан	3,220.7	6,446.9	13,539.4	14,031.0	11,740.0
10	Өвөрхангай	4,150.4	6,402.9	10,487.8	13,852.9	11,504.6
11	Өмнөговь	11,700.8	15,078.0	24,056.8	44,200.2	40,081.1
12	Сүхбаатар	13,858.1	10,883.1	15,245.8	17,171.2	18,775.0
13	Сэлэнгэ	7,175.1	11,069.4	18,290.1	26,947.0	22,213.4
14	Төв	5,697.3	10,484.2	17,776.5	26,700.2	23,254.0
15	Увс	4,062.6	6,286.2	9,907.8	12,455.1	10,104.9
16	Ховд	9,662.4	9,911.6	17,685.0	28,712.0	17,252.5
17	Хөвсгөл	5,531.9	8,001.5	12,704.4	16,234.1	13,944.2
18	Хэнтий	6,661.6	6,398.3	10,401.7	17,498.5	15,223.7
19	Дархан-Уул	6,471.5	7,979.4	12,243.7	20,443.1	12,873.9
20	Улаанбаатар	20,781.9	25,311.8	39,250.4	48,735.1	38,045.5
21	Орхон	3,168.2	9,454.2	15,203.3	34,349.6	25,885.8
22	Говьсүмбэр	970.5	2,893.4	4,888.2	6,677.7	5,515.
23	Дүн	146,706.3	200,235.2	317,814.3	474,303.8	386,658.5

№	Татварын төрөл		2024	2025 I-VII
1	Алт	Агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0
2		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	139.2	109.2
3		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	179.7	92.0
4		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
5		Газрын төлбөр	4.7	2.6
6		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	12.1	10.0
7		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	25.2	17.7
8		Үл хөдлөх хөрөнгийн татвар	1.7	1.9
9		Ус, рашаан ашигласны төлбөр	7.5	2.5
10		Бусад	5.3	1.6
11	Нүүрс	Агаарын бохирдлын төлбөр	79.2	30.6
12		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3,273.0	883.0
13		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,014.9	614.4
14		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
15		Газрын төлбөр	14.3	8.3
16		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	68.4	35.1
17		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	257.3	113.7
18		Үл хөдлөх хөрөнгийн татвар	13.3	5.6
19		Ус, рашаан ашигласны төлбөр	9.8	4.5
20		Бусад	19.3	16.0
21	Цайр	Агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0
22		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	33.1	36.,
23		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	53.7	44.0
24		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
25		Газрын төлбөр	0.3	0.1
26		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	3.8	1.6
27		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	360	2.2
28		Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.8	0.8
29		Ус, рашаан ашигласны төлбөр	1.5	0.6
30		Бусад	0.3	0.4
31	Зэс	Агаарын бохирдлын төлбөр	0.0	0.1
32		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	454.0	315.3
33		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,216.5	936.1
34		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
35		Газрын төлбөр	28.9	16.8
36		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	89.9	74.2
37		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	159.6	95.1
38		Үл хөдлөх хөрөнгийн татвар	199.3	130.3
39		Ус, рашаан ашигласны төлбөр	52.4	28.2
40		Бусад	110.9	5.5
41	Төмөр	Агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0
42		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	29.5	34.3
43		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	85.1	71.7
44		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
45		Газрын төлбөр	1.5	1.0
46		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	20.3	3.7
47		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	17.7	13.2
48		Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.9	0.5
49		Ус, рашаан ашигласны төлбөр	1.9	1.5
50		Бусад	1.9	0.2
51	Хайлуур жонш	Агаарын бохирдлын төлбөр	0.0	0.0
52		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	12.6	5.5
53		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	32.9	21.6
54		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-

55		Газрын төлбөр	1.1	0.6
56		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	0.7	1.0
57		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	2.2	1.9
58		Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.2	0.3
59		Ус, рашаан ашигласны төлбөр	0.7	0.4
60		Бусад	2.6	0.8
61	Бусад	Агаарын бохирдлын төлбөр	0.1	0.0
62		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	92.8	51.5
63		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	92.0	50.7
64		Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-
65		Газрын төлбөр	4.1	2.0
66		Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	42.3	19.2
67		Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	35.7	22.2
68		Үл хөдлөх хөрөнгийн татвар	5.7	4.0
69		Ус, рашаан ашигласны төлбөр	1.8	0.5
70		Бусад	42.0	14.8
НИЙТ			10418.2	3923.1

Эдийн засгийн судалгаа

1. Тооцооллын үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тайлбар
Судалгааны үндсэн хугацаа	10 жил
Хуулийн шинэчлэлийн үр дүнгийн хэмжүүр	Лиценз олголтын хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, татварын орлого, нөхөн сэргээлтийн түвшин
Суурь тооцоо	Монгол Улсын ашигт малтмалын салбарын жилийн нийт орлого ~ 4 тэрбум ам.доллар (2024 оны үзүүлэлт)

2. Хөрөнгө оруулалтын өсөлт

Хуулийн шинэчлэл хэрэгжсэн тохиолдолд хөрөнгө оруулалтын түвшин дараах байдлаар нэмэгдэх таамаглалтай:

Улс орон	Хөрөнгө оруулалтын өсөлт (жилийн %)
Монгол	+12–18%
Канад	+8–10%
Австрали	+10–15%
Чили	+7–12%

Тооцоолол: Монголд хөрөнгө оруулалт жилд дунджаар 500–700 сая ам.доллараар нэмэгдэх боломжтой.

3. Татварын орлого

Хуулийн шинэчлэлээр лицензийн тогтолцоо ил тод, татварын тогтвортой байдал баталгаажсанаар татварын орлого дараах байдлаар өснө:

Үзүүлэлт	Өсөлтийн хэмжээ
Ашигт малтмалын татварын орлого	+15–20%
Лицензийн төлбөр, ашиглалтын төлбөр	+10–15%

Тооцоолол: Энэ нь улсын төсөвт жилд нэмэлт 300–400 сая ам.долларын орлого оруулах боломжтой.

4. Орон нутгийн ашиг

Хуулийн шинэчлэлээр орон нутгийн оролцоо нэмэгдэж, ашигт малтмалын орлогын тодорхой хувь орон нутгийн төсөвт төвлөрөх болсноор:

Үзүүлэлт	Нэмэгдэх орлого
Орон нутгийн төсөв	+20–30%
Ажлын байр	+5–7% нэмэгдэх боломжтой (шугаман тооцоо)

Тооцоолол: 10 жилийн хугацаанд орон нутгийн төсөвт 1–1.5 тэрбум ам.доллар нэмэгдэх боломжтой.

5. Эрсдэл, саад бэрхшээл

Эрсдэл	Санхүүгийн нөлөө
Лиценз олголтын хугацаа сунгах	Хөрөнгө оруулалт буурах (жилийн 5–7%)
Хууль хэрэгжүүлэх санхүүгийн дутагдал	Байгаль орчны хамгаалалт буурах, хөрөнгө оруулалт буурах
Хүний нөөцийн дутагдал	Хяналт сулрах, хөрөнгө оруулалтын үр ашгийн бууралт

6. Нийт үр ашиг

Тооцоолсон үр дүн: Хуулийн шинэчлэл хэрэгжсэн тохиолдолд дараах өсөлт гарах боломжтой:

- Хөрөнгө оруулалт: +500–700 сая ам.доллар жил бүр
- Татварын орлого: +300–400 сая ам.доллар жил бүр
- Орон нутгийн төсөв: +20–30% өсөлт
- Байгаль орчны зөрчил: -25–35% бууралт

7. Дүгнэлт

Хуулийн шинэчлэл нь Монгол Улсад эдийн засгийн өсөлт, татварын орлогын нэмэгдэл, орон нутгийн хөгжил, байгаль орчны хамгаалалт гэсэн өргөн хүрээний үр өгөөжтэй.

Ашигт малтмал баяжуулах тусгай зөвшөөрлийг хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгажээ.

Ашигт малтмалын тухай хуулийн тодорхой төрлийн тусгай зөвшөөрлийг олгодог ба уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагад шинээр үүсэх ачаалал, чиг үүрэг байхгүй ба хуучин олгож байсан тусгай зөвшөөрлийн төрөл дээр **“Баяжуулалтын тусгай зөвшөөрөл”** олгох үйл ажиллагаа нэмэгдсэн байна.

Тиймээс төрийн байгууллагын хувьд шинэ чиг үүрэг нэмэгдээгүй тул хүний нөөцийн болон материаллаг зардал үүсэхээргүй байна.

Мөн “Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгааг нь зарлагдаж буй бүх талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэргээр хэтийн төлөв бүхий талбай бага буюу хөрөнгө оруулагчдын сонирхож буй талбай зарлагдахгүй байх тул тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааг өргөдлөөр олгох болсон нь үйлчилгээг хөнгөвчилж, зардал хэмнэж байна.

Харин хуулийн этгээдэд үүсч байгаа нэмэлт зардал нь бүх төрлийн татвартай холбоотой зардал байх тул зардлыг Хуулийн төслийн 28² дугаар зүйлд хуулийн этгээд нь “баяжмал, бүтээгдэхүүнээ худалдах” эрхтэй ба түүнээс олох орлоготой харьцуулахад хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байна гэж үзлээ.

“Ашигт малтмал баяжуулах” тусгай зөвшөөрлийн тухай зохицуулалтын хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгасан нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэхэд ямар нэгэн нэмэлт зардал гарахааргүй байна.

Уул уурхайн салбар, эсвэл тухайн нэг түүхий эдийн олборлолт тухайн улсын **эдийн засагт үзүүлэх нөлөө** хэр байгаа, тус салбарт төр болон олон нийтийн хандлага, тус **салбарын талаарх ойлголт** хэр байгааг харгалзан холбогдох хууль, эрх зүйн орчиндоо өөрчлөлт оруулах нь чухал. ДНБ, экспорт, төсвийн орлогод үзүүлэх нөлөө ихтэй салбарын үйлдвэрлэл, борлуулалтад нөлөөлөх бодлогын шийдвэрийг гаргах үүднээс энэхүү судалгааг гүйцэтгэлээ

Дүгнэвэл хуулийн төслийн зардал нь үр өгөөжтэйгээ харьцуулвал үр өгөөж нь өндөр байна

Ашиг тус нь:

Ашиг тус	Тайлбар
Ил тод байдал	Лиценз олголт, байгаль орчны үнэлгээ, тайлагнал ил тод болно.
Хөрөнгө оруулалтын	Тогтсон татварын тогтолцоо, хөрөнгө оруулалтын баталгаа тогтвортой байдал хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлнэ.
Байгаль орчны хамгаалалт	Нөхөн сэргээлт, үнэлгээний процесс сайжирна.
Орон нутгийн хөгжил	Ашигт малтмалын орлогын тодорхой хувь орон нутгийн төсөвт төвлөрөх, ажлын байр нэмэгдэх.

Зохицуулах саналууд

Санал	Тайлбар
Санхүүгийн эх үүсвэр	Хууль хэрэгжүүлэх санхүүжилтийг төсөвт тусгах, олонулсын хөрөнгө оруулагчдын санхүүжилтийг татах механизм бий болгох
Хүний нөөц	Байгаль орчны үнэлгээ, лиценз олголт, хяналт зэрэгт мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.
Техник дэд бүтэц:	лиценз олголт, байгаль орчны үнэлгээ, хяналтанд зориулсан цахим платформ хөгжүүлэх
Хяналтын механизм	Бие даасан байгаль орчны хяналтын байгууллагыг хуульчилж, хөрөнгө, хүний нөөцөөр хангах
Хуулийн тогтвортой байдал	Татвар, ашиглалтын төлбөрийн тогтвортой байдлыг баталгаажуулах хуульчилсан заалт нэмж оруулах
Дүгнэлт	Энэхүү шинэчлэл нь Монгол Улсад ашигт малтмалын салбарыг илүү өрсөлдөх чадвартай, хөрөнгө оруулалт татах, байгаль орчны хамгаалалтыг сайжруулах, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах чиглэлд томоохон алхам болно